



**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 02

Өмнөдэлгэр сум

Өмнөдэлгэр сумын хүнс, худалдаа,  
үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийг  
хөгжүүлэх 2026 оны арга хэмжээний  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дүгээр зорилтын 2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Есдүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Өмнөдэлгэр сумын Хүнс, худалдаа, үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Товлосон хугацаанд төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж жилийн эцэст ИТХуралд тайлагнахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Одончимэг)-т даалгасугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ИТН тогтоол

**232600102**

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны  
02 дугаар сарын 30-ны өдрийн Есдүгээр  
хуралдааны 02 дугаар тогтоолын  
1 дүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМ ХҮНС, ХУДАЛДАА,  
ҮЙЛЧИЛГЭЭ, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ 2026 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Зорилго

Сумын хэмжээнд хүнсний аюулгүй байдал, дотоодын үйлдвэрлэл, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих замаар орон нутгийн эдийн засгийн идэвхжил, ажлын байрыг нэмэгдүүлэх.

Хоёр. Зорилт

2.1 Суманд үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэх

2.2 Жижиг бизнес эрхлэгчдийг чадавхжуулах

2.3 Дотоод худалдан авалтыг нэмэгдүүлэх

2.4 Худалдаа, үйлчилгээний соёлыг сайжруулах

2.5 Хүнсний аюулгүй байдлын мэдлэгийг нэмэгдүүлэх

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Төсөв	Санхүүгийн эх үүсвэр
1	Сумын үйлдвэрлэгчдийн бүртгэл, судалгаа гаргах	I улирал	ХААТ	Төсөв шаардахгүй	Дотоод нөөц
2	Хүнсний аюулгүй байдлын анхан шатны мэдэгдэхүүн олгох сургалт зохион байгуулах (Багийн хурал, цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд)	I улирал	МЭТ, ХААТ	Төсөв шаардахгүй	Орон нутгийн төсөв
3	“Дотоодын бүтээгдэхүүнээ дэмжицгээе” аяныг өрнүүлэх	Жилийн турш	ЗДТГ, ХААТ	Төсөвгүй	Сошиал, мэдээллийн самбар
4	Цагаан сар, Намрын баяр үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Улирлын чанартай	ЗДТГ	1-2 сая төгрөг	Оролцогчид
5	Бизнес эрхлэгчдэд хамрагдах боломжтой санхүүгийн дэмжлэг	IV улирал	ЗДТГ	Төсөвгүй	Дотоод нөөц

	олгох төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл тогтмол хүргэх				
6	Худалдаа үйлчилгээний байгууллагуудад стандартын зөвлөмж хүргүүлэх	Жилийн турш	МЭТ, ХААТ	Төсөвгүй	Төлөвлөгөөт ажил
7	Худалдаа үйлчилгээний цэгүүдэд хүнсний аюулгүй байдлын талаар мэдээлэл тогтмол хүргүүлэх	Жилийн турш	МЭТ, ХААТ	Төсөвгүй	Төлөвлөгөөт ажил

Дөрөв. Хүлээгдэж буй үр дүн

4.1 Зөв худалдан авалт хийх анхны мэдэгдэхүүнтэй болох

4.2 Жижиг бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа сайжирна

4.3 Хүнсний аюулгүй байдлын зөрчил буурна